

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пагмын Батмөнх	Дугаар	L253
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Сэврэй сум
Төрсөн газар	Сэврэй сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хоолтын хурал	Сүм хийдийн дугаар	ӨГСВ 008
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 1	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Сэврэй сумын Хоолтын хурал

Гантулга: За та энэ хурлын талаар товч мэдээлэл өгнө үү?

Батмөнх: За энэ хурлыг бол манай хууччуулын ярьж байсныг сонсоход Мүүхуйхав гэдэг эзэн нь тийм түүх домог манай хууччуул ярьдаг юм аа.Тэр Мүүхуйхав гэдэг нь одоо хаанахын хүн байсан юм, бүү мэд ээ.Одоо манай өвөг дээдсээс л уламжилсан ийм юмыг та нарт дамжуулахад ийм байна.Энэ хурал одоо энэ шашин бүрхнаас нэлээн өмнө нэлээн олон жилийн хурал хийгдсэн тийм түүхтэй юм гэж би ойлгодог.Ер нь товчдоо л ийм байна.За занэ хурал дээр бол тэр будсан мөхсөн, за дээр нь янз бүрийн хээ хуартай зөн их байхыг би бол сайн мэднэ. За яахав дуганы туурь дээр та нар очих бол энэ хавьд байсныг нь би гадарлах байх.Тийм дөрвөлжин гортиг бий.Тэрнийг та нар үзүүлье.

Гантулга: За тэдийд эдийд байгуулагдсан гэдэг юм уу, тийм байгуулсан талаар?

Батмөнх: За энийг бол би мэдэхгүй юм.

Гантулга: Та тэр хуйхуу нар идсэн гэдэг талаар ямар хүнээс дуулж байсан юм, ер нь ?

Батмөнх: Аа бас настай улсууд л ярьдаг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Аа мөн.

Батмөнх: Настай улсууд л тэгж ярьж байсан.Одоо тэр хүйхүүгүүдыг энэ толгой дээрээс буудаж , дүрвээж байсан юм гэдэг гэж толгойг нь надад зааж өгч байсан.

Гантулга: Лам нарыг хүйхүү нар эндээс орж ирээд ингэж байсан гээд түрүүн бас та нэг дурсаж байсан?

Батмөнх: Аа харин тийм.

Гантулга: Аль уул гэлээ?

Батмөнх: Тэр хойно Хар толгой бий. Тэр Хар толгой дээрээс буудаж дүрвээж байсан юм байна лээ.

Гантулга: Аа мөн мөн.Лам нарыг уу?

Батмөнх: Тийм.

Гантулга: Аа мөн мөн.Тэгээд дүрвээж бурхан юмыг нь сүйтгэж?

Батмөнх: Аа тэгж сүйтгэж байсан гэж л энэ одоо хууччуул ярьдаг байсан. За товчхон ийм л юм байна.

Гантулга: За баярлалаа. Одоо хойд талын Дуганы хурлын тухай асууя, таны ах дүү тийм лам улсууд байсан эгсэн.Тэр талаараа товч, Дуганы хурлын?

Батмөнх: За Дуганы хурлын унзад лам нь Ваанлунпунцаг гэж, Адиагийн Ваанлунпунцаг гэж хүн байсан.Тэр хурлыг удирдаж байсан хүн шиг байна, одоо бодоод байхад.Энийг би ойлгож байгаа юм.За Дуганы хийдийг бол Улаан сахиус тахидаг.Хоолтын хурлыг, хийдийг идчихээд тэр Дуганы хурлыг идэх гэж байгаа мүү ёроос тэр Улаан сахиусны хүчээр зайлуулж байсан юм гэж манай тэр хууччуул ингэж ярьдаг байсан.Тэр Улаан сахиус гэдэг нь хүчтэй сахиус байсан юм аа гэж л манай хууччуул тэгж ярьдаг байсан.Манай Лахрайтынхан л тэгж ярьдаг байсан.

Гантулга: Тэр лам ах нар, өөр тэр Вандан унзадаас гадна ямар лам ах нар байсан гэж байгаа билээ, нэрээр нь?Дуганы хурлын юу юу байсан юм?

Батмөнх: Энхтөр гэж тэрний нагац ах нь байсан.Тэр нэг эм барьдаг хүн байсан юм.

Гантулга: Маарамба?

Батмөнх: Маарамба одоо хүн байсан.За хоёр дүү нь одоо баригдаж тавигдах нь байна шүү.Зайгаа бодохгүй юу гэж захисан чинь, би ямар хурал номонд суух ямар хүнд сурталчилгаа явуулдаг биш, би эм л өгдөг хүн намайг хэн яадаг юм гэж.Тэгээд баригдаж очоод хэлмэгдэж хуваргын дээлээ авахуулж байсан хүн юм гэнэ лээ. Тэгээд хэзээ ч билээ мануус дээрээ ирж л байсан.

Гантулга: Энэ одоо энэ Дуганы хурал ойролцоо эргэн тойрон, одоо энэ хойшоогоо Өвөрхангайн Богд гээд л энэ эргэн тойрон аймаг дотроо Өмнөговийн Булган урагшаагаа Баяндалай гээд л зүүн урагшаа Ноён гээд л хиллэдэг юм байна ш дээ. Ойролцоо энэ нутаг орны хурлуудтай холбоотой байсан талаар мэдэх юм байна уу?

Батмөнх: Мэдэх юм байхгүй. Одоо тийм хурлууд байсныг бол би тууриудыг нь мэднэ.

Гантулга: Ярьж байсан талаар нь бол?

Батмөнх: Аа би тийм юм огт мэдэхгүй. Холбоог нь мэдэхгүй.

Гантулга: Ямар одоо шарын шашны хурал байсан, улааны шашны хурал байсан уу гэдэг талаар бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Аа шарын шашны.

Гантулга: Энэ хийдийн туурин дээр бас барилга байшин нь нураагүй байхад нутаглаж байсан түрүүн та бас хэлж байсан.Бага байхад очиж байсан гээд. Дээр нь ер нь ямар ямар барилга байгууламжууд байсан юм бэ, дуган суварга гээд ярихад?

Батмөнх: За дуганы голд бол дуганы суурь гээд том дөрвөлжин хүрээ байсан. Тэрийг мэднэ. Аа тэр дээд өндрийн оройд бол нэг тийм ширээс татсан тийм суварга байсан.Дээр нь найман тийм шовгор юмтай.Тэрэн дээр нь би бол гарч тоглодог тийм л байсан.Аа тэрийг бол сайн мэдэж байна, би.Аа лам нарын сууц гэдэг бол тийм халуун ангитай, элдэв ганжиргүй тийм юм байсан.Тэрүүнд нь одоо манай ах нарын байж басйан, сүүлд нь дөчин есөн онд бол бааз бариад тавьдаг л байсан л даа.

Гантулга:Тэр лам ах нар чинь тэр баазтай ойролцоо нутаглаж байхдаа энэ нь гол дуган байсан юм аа, ингэж одоо тойроод ярихад энэ тэр одоо лам нарын байшин , манай гэр энд байсан, тэр том ламынх тэнд байсан гэж ер нь ярьж байсан уу?

Батмөнх: Тэгж ярьж байсан.Харин тэрийг нь мэдээд л би.Дуган гэж юу вэ гэдгийг нь бараг мэддэггүй байж шүү дээ.Тэгэхэд энэ тэнд дуганы суурь байсан юм, энэ тэнд суварга нь байсан юм.

Гантулга: Одоо гол цогчин дуган нь байсан гэж ярихад, тэндээс баруун талд нь юу байсан, суварга нь хаанаа байсан юм гээд ингээд тойруулаад яривал:

Батмөнх: Суварга нь хойд орой дээрээ байсан.Дуган нь зүүн хойд энгэр дээрээ байсан.Тэр бас нэг жижигхэн дуган байсан гэж ярьдаг юм аа.Тэр нь хойхно байлуу, хажууханд нь байлуу.Бас нэг жаахан шавар байсан юм аа.

Гантулга: Том жижиг хоёр дуган?

Батмөнх: Тийм.

Гантулга: Өөр дацан , хурал сургуулийн байр байсан, жас байсан энэ тэр гэж байсан уу, ер нь?

Батмөнх: Өө тэр жас байлгүй дээ.Жасыг нь одоо тэр зоонир энэ тэр нь ямар хүн байсныг мэдэхгүй байна.Байсан, тэр нэг Цүндэг гэдэг хүн байсан болов уу, Даваацэрэн гэдэг хүн, аль нь байсныг би мэдэхгүй байна.

Гантулга:Тэр одоо лам нарынх нь байр зүүнээрээ байсан уу, барун талаараа байсан уу?

Батмөнх: Баруун талаараа байсан бололтой юм.

Гантулга: Суваргууд нь бол тэр баруун дээд талдаа байсан юм байна, тийм ээ?

Батмөнх: Зүүн дээд талдаа.

Гантулга: Зүүн дээд талдаа?

Батмөнх: Зүүн, яг зүүн талдаа.

Гантулга: Суварга нь уу?

Батмөнх:Суварга нь бол хойноо.

Гантулга: Аан хойноо?

Батмөнх: Дуган нь бол яг зүүнтээ юм.Халз цухуйтын тэнд.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулдга: Суварга нь бол тэр, баруун хойд өндөртөө байсан уу?

Батмөнх: Аа тэгсэн.

Гантулга: Таныг бага байхад тэр сүм хийдийн барилга байгууламжийг барьсан тэр барилгын материал зөн энэ тэр гээд л зөндөө овоолгоотой байсан уу?

Батмөнх: Өө янз янзын юм. Тэр зөн, хөх түүпий, улаан түүпий, шавар түүпийнүүд зөндөө л байдаг байсан.

Гантулга: Өөр ямар барилгын материал байсан, одоо зөнгийн гадуур гоё хээ хуартай?

Батмөнх: Хээ хуартай юм байгаагүй ээ, одоо тэр баахан л ялгарсан өнгөтэй юмнууд л байдаг байсан юм. Арзайсан арзайсан юмнууд л байсан. Одоо харахад тэр Улаанбаатар хотод байгаа дуганы юу шиг...

Гантулга: Орой дээвэр?

Батмөнх: Орой дээвэр шиг, тэрүүнтэй адилхан тийм хуартай хуартай юмнууд өнгөлдөг л байсан. Баахан хээтэй.

Гантулга: Тэр лам нарын сууж байсан тэр шавар танз байшингууд орой нь бол мод, ямаршуу байсан? Шувуун нуруутай байсан уу, ямар байсан?

Батмөнх: Хавтгай юм л байсан.

Гантулга: Хавтгай юм л байсан уу?

Батмөнх: Тийм.

Гантулга: Одоо энэ Дуганы хурал чинь өдөр тутамдаа тийм ном уншдаг байсан, дүйчэн өдрөө тийм хурал хурдаг байсан талаар ах лам нар чинь ярьж байсан уу?

Шашны зан үйл, одоо цам гарч байсан, сор залж байсан талаар бол юм ярьж байсан уу?

Батмөнх: Ер нь бол юм яриагүй.

Гантулга: Яриагүй?

Батмөнх: Яриагүй.

Гантулга: Таны ээж бол ойрхон байсан, мөргөл энэ тэр хийж...?

Батмөнх: Өө хийлдгүй дээ, энэ чинь.

Гантулга: Тэр талаар бол?

Батмөнх: Дандаа мөргөл эргэл хийдэг байсан.

Гантулга: Тэр талаараа бол юм ярьж байсан уу, тийм цам харайхад очиж үзэж байсан гээд?

Батмөнх: Одоо бодоход энэ цамыг чинь харайдаг газар Баяндалай сумын Байшинтад л цам харайж басан нгэж би дуулж байсан. Энэ чинь одоо тэр үеийн, одоогоор бол жүжиг шиг юм аа даа, ер нь.

Гантулга: Тийм, бүжигтэй тийм?

Батмөнх: Тийм.

Гантулга: Тэрний талар бол жаахан дэлгэрэнгүй сонссон юм, дурсамжаа яриач?

Батмөнх: За ер нь алга. Одоо энэ Байшинт дээр л тэр Доржсүрэн гээд ах лам л цам харайж байсан. Цамыг чинь одоо хурал болгон хийдэг байсан юм уу, үгүй ээ энийг чинь зарим хурал дээр хийдэггүй байсан. Энэ чинь их том юм байхгүй юу. Цам харайна гэдэг чинь одоо олон янзын дүрд тоглоно, олон янзын хэрэглэл хэрэгтэй байдаг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байхгүй юу гэж настай хүн л тэгж ярьдаг байсан юм.Би цамд харайж байсан, одоо энэ орой дээгүүр гардаг л байсан гэж ярьдаг байсан юм.

Гантулга:Тэр Дуганы хурал одоо ингээд сургууль дацангууд байна ш дээ.Зурхай эмнэлэг, гүн ухаан одоо далд тарни гээд тийм сургуулийн талаар дуулсан юм байна уу?

Батмөнх: За тэр талаар алга.Бодвол тэр гүн ухааны л юм байх.Тэр дацан энэ тэр юм бол байх л байх.

Гантулга: Маарамбууд?

Батмөнх: Маарамбууд бол тэнд байгаагүй байх аа.Ганц хоёр хүн ирж тэр сүмд сурж байсан байх даа.Гэхдээ энэ Дуганы голд чинь Гочоо маарамба гэж сууж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аа дуган дээр?

Батмөнх: Тийм.Халхын дөрвөн маарамбын нэг нь гэж Монгол улс тооцож байсан юм гэнэ лээ.

Гантулга: Зөв зөв.

Батмөнх: Тэр Гочоо маарамбын талаар сайн судлая гэх юм бол тэр Цоожид зурхай нь бий, тэр материал нь ч бий.

Гантулга: Зүгээр нэг аймгийн тухай бичсэн...?

Батмөнх: Аа тийм.Тэр Гочоо маарамбын талаар ер нь бас их л юм бичсэн харагдана лээ.Тэр хүн бол сайн мэдэж байгаа, тэр бол бас төрөл садангийн нь ч болох хүн байгаа.Түүний эцэг нь түүний шавь байсан юм.

Гантулга: Аа мөн мөн. Тэр Гочоо маарамбын?

Батмөнх: Тийм.

Гантулга: Аа зөв зөв. Хэн гэж хүн байсан юм?

Батмөнх: Жандан гэж хүн байсан юм.Энэ Говь Гурван сайхны баруун сайхны ард нутагладаг, эм барьдаг хүн байсан юм.

Гантулга: бас маарамба хүн байж?

Батмөнх: Аа чухам маарамбын зэрэгт хүрсэн юм уу , бүү мэд.Зүгээр эм л барьдаг хүн байсан юм.

Гантулга: Өөр тэр Дуганы хурлын эрдэмтэй алдартай маарамба, зурхайч?

Батмөнх: Харин тэр Гочоо маарамба байна.

Гантулга:Өөр?

Батмөнх: Тэр Дөндөө гэдэг хүн эм барьдаг хүн байсан байна.

Гантулга: Цүндэг гээд үү?

Батмөнх: Дөндөө, Энхтөр Энхтөр.

Гантулга: Аа Дөндөө гэж авгайлдаг байсан юм уу?

Батмөнх: Дөндөө гэж авгайлдаг байсан юм.

Гантулга: Таны тэр унзад ахыг чинь юу гэж авгайлдаг байсан юм?

Батмөнх: Цондоо.

Гантулга: Цондоо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Тийм.

Гантулга: Том дуутай л гэсэн үг үү, тийм ээ?

Батмөнх: Тийм, том дуут Цондоо гэдэг байсан юм .

Гантулга: Дөндөө гэдэг нь?

Батмөнх: Дөндөө гэдэг нь тэр нагац ах нь.

Гантулга: Үгүй ээ ер нь утгыг нь яривал, тэр авгайллынх нь?

Батмөнх: Аа энэ Дөндөө гэдэг нь бас авгайлж өгсөн нэр нь юм.

Гантулга: Тийм.

Батмөнх: Өөрийг нь болвол Энхтөр гэдэг хүн.

Гантулга:Тийм, тэр утгыг нь яривал, Дөндөө гэдэг нь яагаад ингэж авгайлж дуудах болсон юм? Түүхээр бол?

Батмөнх: Аа, за чухам тэрийг нь мэдэхгүй юм. Энэ тэндээс одоо энэ хурал дээр ирж том лам нар одоо номт тавьж байсан, ингэж абшиг хүртээж байсан талаар тэр ах лам нар чинь ярьж байсан уу?

Батмөнх: За тэрийг ер нь би юм дуулаагүй.Санах юм алга надад.

Гантулга: Тэр лам нар нь хийдийнхээ хаагуур нь амьдарч байсан, тэр байшин савных нь тууриар харвал?

Батмөнх: Үгүй ээ, тэр байшин нь байдаг, гэрийн довжоо нь байдаг.Тэр дандаа л баруун талаар нь шахуу байдаг байсан ш дээ.

Гантулга: Гол дуган хийдийнхээ баруун талаар нь уу?

Батмөнх: Тийм, баруун талд нь л голцуу байдаг байсан.

Гантулга: Жас, жасын талаар бол?

Батмөнх: Аа зүүн талд нь бол, тэр дуганыхаа урд талаар л жас байдаг байсан, гэрээ бариад байдаг байсан. Байшин нь бол баруун талаараа л байдаг байсан.

Гантулга: Одоо тухайн үед таны ээж ч юм уу, энэ эргэл мөргөл хийж байсан нутгийн сүсэгтнүүд ямар зан үйл хийдэг байсан, хүрээ хийдээ гороодог байсан уу, биеэрээ төөлж мөргөх ч гэдэг юм уу?

Батмөнх: Аа төөлж мөргөнө.Тэр дуганаа , түр суваргаа гороолж мөргөдөг тийм л юм лав хийдэг байсан , улсууд.

Гантулга: Өөр сор залах энэ тэр юмнуудад ирж оролцож байсан талаар бол дуулсан юм?

Батмөнх: За ер нь мэдэхгүй байна , би. Сор залдаг байсан юм уу, үгүй юм уу мэдэхгүй байна.Гэхдээ болвол тэнд бол хэн гэж, Төгрөг гэдэг хүн...

Гантулга: Хэн гэнэ ээ?

Батмөнх: Төгрөг.Тэр нь одоо өнөө лүйжин тавина.Одоо тийм зоч...

Гантулга зоч?

Батмөнх: зоч, өнөө агуйгаар хоноод хүний чөмөгний яс энэ тэр дэрлээд явдаг ч байсан юм уу, ингэж явдаг байсан юм байна.

Гантулга: Зөв зөв.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Тэгээд бас эргэл бас хийдэг.Тэгсэн чинь өнөө л одоо чөтгөр шулам , буг дарна л гэж тийм л юм хийдэг байсан байна ш дээ.Тэгээд тийм юмаа хийгээд, дарах гэсэн чинь сүүлдээ өөрийгөө дарж дийлэхээ байгаад, бүр одоо баригдаад.Тэгээд Дуганы лам нарын хүчээр ,тэрнээс нь салгаж тэгээд сүүлдээ өөрөө хар болж орсон юм гэнэ лээ гэж түүх ярьдаг юм.

Гантулга: Өөр одоо Гочоо маарамба эд нарын талаар?

Батмөнх: Аа Гочоо маарамба бол Дуган дээр сууж байсан, эм барьж байсан хүн.Чухам тэрнээс л болж манай ах маарамба болсон юм уу даа, тэр чинь маарамба хүн гэж байгаа шүү.Одоо эрдэмтэй л хүн байна., одоогоор бодох юм бол. Тэрийг болвол би сайн мэдэхгүй.Тэрийг болвол Цоож сайн мэднэ.

Гантулга: Өөр одоо тэр том лам нартай холбоотой , таны үнзад ахтай холбоотой гоё тийм сонин домог, тийм түүх болчихсон яриа байна уу?

Батмөнх: За даа, ер нь тийм юм алга даа.Тэр зуур домог яриагаар бол тэр цач, тэр лүйжин тавьдгийг тэр цач болно гэдгийг л тэр хурлын хийд дээр улсууд л нийлж дарж, тэр хүнийг аварч байсан тийм түүхийг л мэднэ.

Гантулга:Тэр эргэн тойрон байгаа тахилгатай газар усыг нэрлэвэл?

Батмөнх: За урд нь Эрдэнийн овоо гэж байгаа.Намайг бас мэдээ орсон малд явчихсан байхад нутгийн сахилгагүй хүн овоог нь бутраагаад хаячихсан байхад жалгаар дүүрэн цай буцалдаг байхыг л би мэднэ.

Гантулга: Аа их цай өргөж?

Батмөнх: Аа их цай өргөдөг тийм газар байсан юм байна л гэж би ойлгож байгаа.

Гантулга: Өөр?

Батмөнх: Өөр одоо яахав дээ, энэ Улаан овооны урд талд нэг овоог Дондов гэдэг хүн сүйтгэсэн. Хавилангийг нь боож хөдөө аваачиж хаяж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Улаан овоо гэдэг чинь тэр Дуганы хурлаас?

Баимөнх: Аа биш ээ, энүүхэн энэ хойшоо бий.

Гантулга:Тэр Дондов гэдэг чинь бас жаахан тиймэрхүү хүн байсан уу?

Батмөнх: Хай даа, одоо.

Гантулга: Тэр хэлмэгдлийн талаар таны дуулсан юм байвал, ах лам нартайгаа холбоотой, өшөө тэндхийн лам нартай хобоотой, хийд байшинг нь цоожилж,юмаа хураалгасан энэ тэр гээд?

Быатмөнх: Тэр Гочоо маарамба явж ирээд л баригдсан.Нэг хоёр хүн байлгүй дээ, бас нэрийг нь сайн санахгүй байна.

Гантулга: Таны ах нарын тухайд ярихад?

Батмөнх: Тэр манай ах нарын тухайд ярихад Энхтөр гэдэг хүн цаазлагдсан.Аа тэр манай нагац ах бол аймагт очиж суугаад...

Гантулга: Баригдаж?

Батмөнх: Нэг баригдаж нэг сар суугаад л , бага ах нь гурван сар суугаад л буцаж ирж байсан.

Гантулга: буцаж ирж байсан?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Тийм.

Гантулга:Тэд нь тэгээд ингэж ингэж байсан гээд юм ярьж байсан уу, ер нь? Ингэж барьж аваад, ийм хүн ингэж байцаагаад гэдэг юм уу?

Батмөнх: Аа ер нь тэгээд л баахан тулган шаардлага л хийдэг. Чи ямар эсэргүү, ямар ажил хийж байсан бэ, гадаадаас одоо ямар сүлбээтэй байсан бэ, чи одоо ямар хүнийг яаж мүнхруулж байна вэ гэж ингэж л байцаадаг байсан гэж л ярьдаг басйан.

Гантулга: Тэр одоо тухайн сүм хийдийг хаалаа ш дээ, лам нарыг нь тэгээд барьлаа. Тэгэхээр одоо туурин дээр нь үлдсэн байшинг одоо сумын захиргаа ч байдаг юм уу, ямар нэгэн зорилгоор ашигласан юм байна уу? Байр сав ч гэдэг юм уу?

Батмөнх: За ер нь Дуганы хийд дээр бол тийм юм байгаагүй. Гэхдээ сонгуулийн тойрог нэг хэсэг байдаг байсан.

Гантулга: Аан за, хэдий үед?

Батмөнх: Дөчин хэдэн оны сонгууль.Бас энэ тавиад оноос хойш, тавиад онд л байхгүй болсон доо.

Гантулга: Байшин саванд нь бас юм хүм хийж байсан, юу хийж байсан гэлээ бас нэг ашиглаж байсан гээд?

Батмөнх: За ер нь ашиглаж байсан юм байхгүй ээ дээ. Айлууд л зоорио тавьдаг байсан. Энэ хавийн л нутгийн улсууд байх юм.Тэгээд одоо ах ламынхаа юм уу, дүү ламынхаа юм уу байшинд л зоорио хийдэг.Тэгээд ер нь тэндхийн сууж байсан лам нар нөгөө эсэргүүний үед л бүгд цугтаагаад л , энийг даваад л бүр хол нутагладаг байсан.

Гантулга: Холхон нутагладаг байсан?

Батмөнх: Өө хол, бүр нутгаасаа гараад явчихсан.Тэгээд л ажил төрлөө өөрчлөөд л ном, судраа хаяад л.Тэгээд ийшээ илрүүлүүд л хэлж байсан юм шиг байгаа юм.Одоо бодоод байхад...

Гантулга: Тэр одоо ах лам нар чинь ингээд том лам хуварга байсан улсуудын шашны зан үйлээс гэртээ одоо сүүлд нууцлаад л ном унших ч байдаг юм уу тийм юм хийж байсан уу, тэр талаар нь жаахан тодруулаач?

Батмөнх: Манай ах бол, манай энэ хоёр ах бол насан өөд болтлоо тэр номоо уншсаар байгаад л насан өөд болсон.Одоо Жадамба номыг өдөр шөнөгүй уншаад л дуусгаад л , маргааш өглөө нь бурхан номынхоо ажилд яваад л өгдөг байсан, залгаад л тэгээд явчихдаг.

Гантулга: Өдөржин шөнөжин л ?

Батмөнх: Аа тийм, өдөр шөнө хоёр л уншдагш хүн байсан, нөгөө л хэдийг?

Гантулга: Их хөлгөн судрууд?

Батмөнх: Аа тийм.Аа манай ах болвол бага ах болвол наян зургаан онд нас барсан.

Гантулга: Жанчив лам гэж байсан гэсэн?

Батмөнх: Тийм, Жанчив лам.Жамбалсанжидыг өдөр болгон уншсаар байгаад л дууссан.Мөн тэгж явж байгаад тэр манай нэг тууж ном байсныг Өмнөговь аймгийн хэлтсийн дарга Улаанбаатар аваад явчихсан.

Гантулга:Тэр тууж номынхоо нэрийг нь хэлээч?

Батмөнх: Юу , Цаасан шувууны тууж.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Цаасан шувууны түүж, аа мөн мөн.Энэ Дуган хурлын тухай танд ингээд гар зураг ч байдаг юм уу, ийм зурсан, сүм хийдийн талаар бол зураг энэ тэр байхгүй юу, тийм ээ?

Батмөнх: Байхгүй ээ, мэдэхгүй.

Гантулга: Бичиж үлдээсэн нөгөө...?

Батмөнх: Аа байхгүй.

Гантулга: Ах лам нарын чинь одоо ийм байсан гээд бичмэлээр бичээд үлдээчихсэн юм?

Батмөнх: Байхгүй ээ байхгүй.

Гантулга: Тэр ах лам нарын чинь багш нь ч байдаг юм уу, том лам нарын зураг хөрөг байхгүй юу?

Батмөнх: Байхгүй.

Гантулга: За ярилцлага өгсөн танд баярлалаа.

Батмөнх: Гэхдээ бас нэг ийм юм байна.

Гантулга: За.

Батмөнх: Манай тэр ах нарын одоо ийм ийм малгай.

Гантулга: Аа мөн, Шашин малгай?

Батмөнх: Шашин малгай ,тийм.За тэгээд л тэр ном эд нарыг чинь одоо хэрэглэдэггүй шахуу, одоо муу сайн агүйд, дөчин есөн оны зудаар манайх хойшоо нүүгээд агүйд тавьчихсан байсан чинь бүгдийг нь аваад сүйтгээд хаячихсан байсан.

Гантулга: Үгүй ээ ер.

Батмөнх: Гол юм нь тэгээд дуусчихсан юм, манай хувьд.

Гантулга:Ном судар энэ тэр бол уламжилж үлдсэн юм ер байхгүй юу?

Батмөнх: Байхгүй, байгаа нь харин тэр ойр номууд нь шавь нь л яачихсан.Тэнд нэг ойр номууд...

Гантулга: Тэр чинь хэний гар дээр байгаа гэлээ?

Батмөнх: Сугар гэдэг хүний.

Гантулга: Ямар холбоотой юм, танайхтай?

Батмөнх: Манай тэр нагац ахын охин нь байгаа юм.

Гантулга: Энхтөр гэдгийн үү?

Батмөнх: Биш ээ, тэр Жанчив гэдгийн.

Гантулга: Аа мөн мөн.Тэгээд тэр хүн дээр хадгалагдаж байгаа?

Батмөнх: Тэр хүн дээр байгаа.Зүгээр нэг авдар сав нь бий байх аа, тэр.

Гантулга:Тэр цаасан шувууны түүж гэдгийг нь хэн гэдэг хүн аваад явсан гэнэ ээ?

Батмөнх: Батцэрэн, Өмнөговь аймгийн хэлтсийн дарга Батцэрэн.

Гантулга: Та ер нь тойроод энэ урагшаагшаа Дэрсний хурал гээд байна ш дээ?

Батмөнх: Тийм.

Гантулга: Юу билээ, Турын дэрс, Цагаан дүрс билүү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Тийм.

Гантулга:Тэгээд энэ Байшинтын хурал гээд энэ талаар дуулсан юм байна уу, хутагт хувилгаадынх нь талаар?

Батмөнх: Тэр одоо Жасрай гэгээн, Шавруун ламтан энэ тэр л тэрүүгээр нутагладаг тэр нутгийн нь газар л даа.Тэр одо Жасрай гэгээнийг тэр зэвсэгтэд оршуулсан юм гэнэ лээ.

Гантулга:Зэвсэг ээ?

Батмөнх: Тийм.

Гантулга: Аан за.Тэр нь хаахна байдаг юм бол?

Батмөнх: Одоо энэ Зөөлөнгийн зүүн сүүл рүү байгаа.

Гантулга:Тэр өөрөө жамаараа үхсэн юм уу, хэлмэгдээд алуулчихсан юм уу?

Батмөнх: Өөрөө жамаараа, залуудаа хорин хэдтэй нас барсан гэдэг байх аа.Тийм, гуч хүрсэн юм уу үгүй юм уу, тийм л нас барсан юм гэнэ лээ.

Гантулга:Тэр одоо хэлмэгдлээс өмнө үү?

Батмөнх: Аа хэлмэгдлээс өмнө юм уу, хэдүүхэнд юм.Тэр үед ч юм уу.Тэр өөрөө нас барсан.Тэгээд тэр Зэвсэгт ууланд тавьсан.

Гантулга:зэвсэгт уул аа?

Батмөнх: Тийм.

Гантулга: Тэр хийдээсээ хаашаагаа байдаг юм?

Батмөнх: Хойшоо, баруухан хойшоо байдаг юм.Тэгээд тэр Жасрай гэгээн гэдэг, Жасрай гэгээн гэдэг чинь тэгсэн юм гэнэ лээ.Тэнд тавиад явсан, тэгээд тэнд тавьсан, тэрээд л одоо нас барсан хүнийг тавихад ер нь иймээ тиймээгүй сайн төрөлдөө очсон, одоо манай эндээс сумаас л тийшээ аваачиж тавьдаг юм л даа.

Гантулга: Хүн тавьдаг газар болох нь?

Батмөнх: Тийм, сумаас зуу гаран км яваад.Эндээс чинь бас л ная ерээд км явах байх.

Гантулга:Тиймэрхүү?

Батмөнх: Тийм, тэр одоо Жасрай гэгээгий хойд дүр гээд л урд яримад байна дээ.Одоо тэр чинь бол яг байгаа нь тэр.Тэр хүний л дүр явж байгаа нь тэр.

Гантулга:Тэр Шавруун ламын талаар бол дуулсан юм?

Батмөнх: Аа тэр Шавруун лам ихл олон адуутай, их л баян хүн байсан юм гэнэ лээв Шавруун лам тэр Зүүн сайхны энгэрээд...

Гантулга:Их уран хүн байсан гээд зарим улсууд ярих юм?

Батмөнх: Аа тийм, их л олон малтай их л баян хүн байсан юм гэж ярьдаг юм , мэдэхгүй юм аа.

Гантулга: Холч дээрээс харахад одоо урагшаа ийм гээд, ингээд газрынх нь нэрээр нар зөв эргээд ярихад?

Батмөнх: За одоо хойд талд нь бол Арц Богд байгаа Өвөрхангайн нутаг.Тэр Будны ар гэж байгаа , ойрхон нутагтаа ярих юм бол.Тэгээд л баруун хойшоо явахаар яг нутгаараа ярих юм бол Эрдэнэбулаг , Баяннуруу.

Гантулга: Энэ Баяннуруу нь урд юм байна тийм ээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Батмөнх: Энэ Баяннуруу гэдэг юм.Тэгээд л урагшаа энэ Сэврэй харагдаж байгаа. Баруун урд талд нь одоо Түвшин хайрхан, Эрээн хайрхан гэж байгаа. Ийм л нутагтай.

Гантулга: Одоо Дуган хурлын талаар яриач?

Батмөнх: Харин Дугахнаас харахад л ийм газрууд харагдана даа.

Гантулга: Энэ Хоолтын хурлын?

Батмөнх: Аа энэ Хоолт ч яахав дээ, энэ Хоолт бол Баяннэурууны өвөрт байгаа.Урд нь Зөөлөнгийн гэтэл байна.Энэ зүүн талдаа Баянцагааны гэтэл байна.

Гантулга: Аа ингээд л болоо?

Батмөнх: Ингээд л болоо.

Гантулга: Ус булгийг нь яривал?

Батмөнх: Аа ер нь олон юм байлгүй яахав.

Гантулга:Тэр Дуган хурлын нэг гурван ус байсан гээд та түрүүн хэлж байсан?

Батмөнх: Аа тэр Дуган голын чинь Арзхаанбулаг, Дундхаанбулаг тэгээд тэр Дуган голын чинь урд хэдэн булгууд байгаа юм.Тэрүүхэн голдоо л тэр гурван устай.

Гантулга:Задгай устай юу?

Батмөнх: Дандаа задгай ус.

Гантулга: Энэ Хоолтын хурлын энд задгай ус бий юу?

Батмөнх: Байгаа байгаа, энэ гадуур урсдаг нь энэ.Тэр хийдээсээ...

Гантулга: Юу гэж нэрлэдэг юм, Хоолтын ус гэх үү?

Батмөнх: Хоолт гэнэ.Тэрнээс хйош энэ Шанд гэдэг нь бас доошоо бас задгай гарчихдаг юм.Гантай жил гардаггүй юм.

Гантулга:Энэ одоо сүм хийдийг тарааж нураасан үеийн үлдэгдэл, хадны агуй дээрх юм энэ тэр та үзэж дуулж байсан уу?

Батмөнх: За даа үгүй ээ, үгүй.Ер нь агуй магүй элдэв юмсыг нь цөлмөөд дууслаа ш дээ.Тэр улсууд нь үрээд тараад үгүй хийгээд...Ёстой нөгөө агуй магүй номны цөгц мөгцний юм та нар сурвал байдаг л байх л даа, энд тэнд.

Гантулга: Тийм л байх даа.

Батмөнх: Тийм.

Гантулга: За ярилцлага өгсөн танд баярлалаа.

Батмөнх: За та нарт баярлалаа.

Гантулга: За за.